

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУЛГАН-АЗЗА ТӨХК-ий 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/З/СТА-ТБӨӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2019 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын захирал
бөгөөд

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70352580 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivanaudit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12

2.1. Оршил

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Булган АЗЗА ТӨХК захирал Б.Батсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Булган АЗЗА ТӨХК нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 01-нээс 2020 оны 03 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван аудит ХХК орхон салбарын аудитор Б.Пүрэвсүрэн /Булган аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ гурвалсан гэрээний дагуу хариуцаж хэрэгжүүлэв.

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Далайван аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн, аудит хийлгэх хүсэлтийг 2020.03.02-ны өдрийн 51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн, Улсын болон орон нутгийн зам засварын арчлалтыг гүйцэтгэх замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, харилцагчдаа дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдал болон зорчигчдын ая тухтай аялах нөхцлийг бүрэн хангахад” оршино.

Булган АЗЗА ТӨХК-ий үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.
Үүнд:

- Авто зам засвар, арчлалт

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журам.
Үүнд:

- Компаний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Ахмадийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Авто замын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Булган АЗЗА ТӨХК-ий мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган АЗЗА ТӨХК-ий санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Макс программ хангамж ашигладаг байна.

Булган АЗЗА ТӨХК-ий албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган АЗЗА ТӨХК-ий бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 681,102.3 мянган төгрөгөөс тооцон 13,622.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 732,063.8 мянган төгрөгөөр буюу 137 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,744.7	1,588.8	-11,155.9
Авлага	133,192.5	1,033,638.5	900,446.0
Урьдчилгаа			
Бараа материал	187,360.9	127,626.1	-59,734.8
Үндсэн хөрөнгө	1,328,130.6	1,230,699.1	-97,431.5
Нийт хөрөнгө	1,964,643.9	2,696,707.7	732,063.8
Өр төлбөр	849,711.1	1,386,634.1	536,923.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,114,932.7	1,310,073.5	195,140.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,964,643.9	2,696,707.7	732,063.8

Тайлант онд нийт авлага 900.4 сая төгрөг, нийт өглөг 536.9 сая төгрөгөөр өссөн байна. Зам засвар арчлалт, Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн засвар шинчлэлт, Улаанбаатар-Дарханы чиглэлийн 207 км түр замын ажилд туслан гүйцэтгэгчээр орж ажилласантай холбоотой ажилд 45 км замыг хариуцан ажиллаж 2019 оны 8 дугаар сарын 24-нд актаар хүлээлгэн өгсөн 882.2 сая төгрөгийн гүйцэтгэсэн боловч Азийн хөгжлийн банкнаас санхүүжигдэх эх үүсвэртэй санхүүжилт хугацаандаа орж ирээгүйн улмаас ндш, түрээс, татвар, шатахуун, харилцагч байгууллага, ажиллагсад болон хувь хүнтэй өр төлбөр, авлага үүсч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,734.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 53,436.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 452,896.7 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 95,300.6 мянган төгрөгийн барилгын засварын материал, 18,095.7 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нийт 619,729.4 мянган төгрөгийн бараа материал худалдан бэлтгэсэн байна. Тайлант онд нийт 1,440.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 61,211.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 461,231.7 мянган төгрөгийн барилгын засварын материал, 5,541.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нийт 679,464.2 мянган төгрөгийн материал зарцуулж 127,626.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

2009 онд Кувейтын сангийн зээлээр бэлтгэсэн машин тоног төхөөрөмжийн 565.2 сая төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй байна. Удирдлагын зардлыг нийт борлуулалтын 23 хувиар буюу 309.4 сая төгрөгөөр төлөвлөсөн ба 304.8 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтаас дугуйт экскаватор 1 ширхэг, крантай майти 1 ширхэг, бага оврын экскаватор 1 ширхэг, байршил тогтоогч 5 ширхэг, зөөврийн компьютер 4 ширхэг, принтер 1 ширхэг нийт 6 төрлийн 13 ширхэг 140.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусгасан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 219 тоот тогтоолоор 130.5 сая төгрөгийн экскаватор 1 ширхэг, Төрийн өмчит бодлого зохицуулалтын газрын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 544 тоот тушаалаар 0.19 сая төгрөгийн 2 хаалгатай ханын шкаф 1 ширхэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 тоот тушаалаар 3.0 сая төгрөгийн ниссан навара маркын авто машин 1 ширхэг, Төрийн өмчийн хорооны 2019 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 525 тоот тушаалаар 46.5 сая төгрөгийн ланд-200 маркын авто машин 1 ширхэг нийт 180.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 5.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр худалдан бэлтгэж бүртгэлд тусгасан байна. Тайлант онд 283.5 сая төгрөгийн элэгдэл хорогдол тооцож нийт хөрөнгийн үлдэгдэл өртөг 4,167.6 сая төгрөг байна.

2.11 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 165,993.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,717.3 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 151,597.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 12,678.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Аудитаар дараах 165,993.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,717.3 мянган төгрөгийн төлбөр барагдуулах акт, 12,678.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Кассаас 1 234.3 мянган төгрөгийн хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн мөн 483.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс өгсөн боловч мөнгө авсан хүн нь тодорхойгүй анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 зүйл "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." гэсэн заалтын дагуу баримт бүрдүүлэн гүйлгээг хийхийг сануулж төлбөр барагдуулах актаар хүргүүллээ.

2. Тайлангийн хугацааны эцэст нийт 92 919.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл, 58 678.0 мянган төгрөгийн дансны өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн Төрийн өмчийн хорооны тогтоолоор Куветын сангаас 17 нэр төрлийн машин механизм, тоног төхөөрөмжийг УХЗээлээр авч одоог хүртэл шийдвэрлэгдэхгүй балансад өглөгөөр бүртгэгдэн олон жил болсон байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 -т заасанчилан Ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргийнхээ дагуу дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж байхыг албан шаардлагаар хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 12,678.9 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган АЗЗА ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн данстай холбоотой 61 асуумж мэдээлэл тайлагнах байснаас 42 удаа хугацаандаа бөглөж 19 удаа хоцроосон байна. Байгууллагын шилэн дансны самбарын мэдээллийг тухай бүр шинчлэн ажилладаг байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар Булган аймгийн төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэл авсан ба менежментийн захидлаар нийт зардалыг бууруулах, төлөвдөгдөөгүй, үр ашиггүй ажил хийж шатахуун, материалын зардлыг хэмнэж алдагдал бууруулах, он дамжсан авлагын эзэн холбогдогчийг тогтоож барагдуулах гэсэн хоёр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн хариуг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/220 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Өмнөн зөвлөмжийн биелэлтийг 70 хувь гэж үзэж байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган АЗЗА ТӨХК-ий 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:

Аудитор

Д.Мягмарсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Огноо

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд газар эзэмших эрхгүй, цутгамал бетонин суурьгүй, цонх хаалга доторлогооны материал зэрэг нь тоногдож байхгүй болсон 10,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 5,222.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 5 тооны амралтын шовгор бүртгэлтэй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 361 тушаалд "Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна", Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д "Барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг барилга байгууламжид бүртгэнэ, НББОУС-16-д "Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа аж ахуй нэгжийн эзэмшиж байгаа хөрөнгийг бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгө дутуу бүртгэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хөрөнгийг бүртгэн авч тайланд тусгах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төрийн өмчийн хороонд барилга байгууламжаас хасуулах хүсэлтийг тавиад шийдвэрлэгдээгүй.

2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн машин механизм тээврийн хэрэгслийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа 181,372.8 мянган төгрөг хөрөнгө, элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдаж байгаа 289, 943.1 мянган төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй байна. Бусад тоног төхөөрөмж, тавилга эд хогшлийн дансанд мөн адил актлах дахин үнэлэх хөрөнгүүд бүртгэлтэй байгаа нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49-д “Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлд тусгаагдан тайлагнагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үндсэн хөрөнгийн дансанд тийм хөрөнгө их байдаг.

3. Бараа материал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагадсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Бараа материал дутагдах, хариуцсан эзэн холбогдогчгүй үр ашиггүй зарцуулагдах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материал худалдан авалт болон зарцуулалттай холбоотой анхан шатны баримт материалын иж бүрдэлийг бүрэн ханган тайланд тусгах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гарын үсэг дутуу няравууд баримтаа дутуу бүрдүүлж байна.

4. Цалингийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Хоолны мөнгөнөөс (шууд бус) орлогоос татвар суутгахдаа нийгмийн даатгалын шимтгэлийн хассан дүнгээс татвар суутган 371.5 мянган төгрөгийн татвар дутуу суутгасан байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.1.4-д “Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр”, 23 дугаар зүйл 23.1-д “Шууд бус орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татвар дутуу суутгах.

4.3. Өгсөн зөвлөмж:

Нэмэгдэл цалин болон шууд бус орлогоос татвар суутгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв суутгах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Мэдээгүй байсан дахин ийм алдаа зөрчил гаргахгүй ажиллана.

5. Авлагын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст авлагын үлдэгдэлд төлөгдөх найдваргүй 7,085.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, авлагын үлдэгдэл найдваргүй авлагын хасагдуулгыг тооцож тайлагнаагүй байна.

5.2. Эрсдэл:

Эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон авлага тайланд бүртгэгдэж авлага цэвэр дүнгээр илэрхийлэгдэхгүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж:

Найдваргүй авлагын хасагдуулгыг байгуулах, авлагын насжилтаар найдваргүй авлагын хасагдуулга хувь хэмжээг удирдлагаар батлуулан найдваргүй авлагын хасагдуулга тооцож авлагыг цэвэр үнэ цэнээр нь илэрхийлэх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Найдваргүй болсон авлагыг бүртгэлийн дагуу хасах арга хэмжээ авна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.МЯГМАРСҮРЭН

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгөн хөрөнгө	12,744,705.29	1,588,849.21
1.3	Нийт хөрөнгө	1,964,643,967.73	2,696,707,728.53
2.4	Өр төлбөр эзний өмч	1,964,643,967.73	2,696,707,728.53

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	1,759,923,488	2,119,281,649.34
2	Борлуулалтын өртөг	2,009,893,320.97	1,728,881,892.77

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,094,360,817.27	1,473,330,716.06
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,213,641,368.50	1,754,531,347.33

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018.12.31	906,027,446.14	712,028,121.46	-503,122,782.08	1,114,932,785.52
2019.12.31	1,086,236,019.14	712,028,121.46	-488,190,594.11	1,310,073,546.49